



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** СБА-2022/05/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт

2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: [narantuyam@audit.gov.mn](mailto:narantuyam@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 99035990

Цахим хаяг: [davaag@audit.gov.mn](mailto:davaag@audit.gov.mn)

Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Захирал: А.Сарангэрэл

Утас: 9988 4842

Цахим хаяг: [gereltekhburtgelaudit03@gmail.com](mailto:gereltekhburtgelaudit03@gmail.com)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа .....	16
4.2 Төлбөрийн акт .....	16
4.3 Албан шаардлага .....	17
4.4 Зөвлөмж.....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах Орон



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.05.25 № 44

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

СҮХБААТАР АЙМГИЙН БИЧИГТ ДЭХ  
ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГА  
Н.АМАРБААТАР ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бичигт дэх Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бичигт дэх Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>24,196,350.97</u></b>	<b><u>20,231,628.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>30,999.86</b>	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>30,999.86</b>	-
3351	Байгууллагаас авах авлага	515.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	30,484.86	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>24,165,351.11</b>	<b>20,231,628.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>6,752,094.00</b>	<b>5,065,503.00</b>
35300	Бэлэн бүтээгдэхүүн	6,752,094.00	5,065,503.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>14,520,257.11</b>	<b>12,664,125.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1,208,630.00	554,100.00
35420	Аж ахуйн материал	7,503,107.11	8,330,670.00
35440	Түлш, шатах тослох материал	2,767,750.00	915,250.00
35470	Бусад хангамжийн материал	3,040,770.00	2,864,105.00
35600	Мал амьтад	2,893,000.00	2,502,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,447,984,911.49</u></b>	<b><u>2,333,081,617.43</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b><u>2,447,984,911.49</u></b>	<b><u>2,333,081,617.43</u></b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b><u>2,128,477,079.49</u></b>	<b><u>2,013,656,285.43</u></b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,971,382,107.40	2,007,045,713.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	(467,661,126.39)	(515,089,056.13)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	236,000,000.00	130,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(106,000,000.00)	(21,666,666.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	752,424,215.48	801,480,152.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	(282,926,419.46)	(409,272,181.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,259,227.00	9,259,227.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,251,966.17)	(8,814,445.43)
39214	Бусад үндсэн хөрөнгө	27,150,000.00	27,150,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,898,958.37)	(6,436,458.41)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b><u>319,507,832.00</u></b>	<b><u>319,425,332.00</u></b>
39301	Програм хангамж	39,989,207.00	39,989,207.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(539,375.00)	(621,875.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	280,058,000.00	280,058,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,472,181,262.46</u></b>	<b><u>2,353,313,245.43</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,472,181,262.46</u></b>	<b><u>2,353,313,245.43</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>2,313,613,220.61</u></b>	<b><u>2,313,613,220.61</u></b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,313,613,220.61	2,313,613,220.61
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b><u>158,111,400.01</u></b>	<b><u>39,243,382.98</u></b>
51210	Өмнөх үеийн үр дүн	158,111,400.01	158,111,400.01
51220	Тайлант үеийн үр дүн	-	(118,868,017.03)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	456,641.84	456,641.84
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,472,181,262.46</u></b>	<b><u>2,353,313,245.43</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,156,375,013.58</b>	<b>694,239,308.87</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>526,167,513.58</b>	<b>103,989,508.87</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>526,167,513.58</b>	<b>103,989,508.87</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	525,917,513.58	103,690,508.87
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	38,269,423.58	22,420,454.90
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	487,648,090.00	81,270,053.97
120009	Бусад орлого	250,000.00	299,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>630,207,500.00</b>	<b>590,249,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>630,207,500.00</b>	<b>590,249,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	630,207,500.00	590,249,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>751,266,148.63</b>	<b>813,074,215.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>751,266,148.63</b>	<b>813,074,215.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>605,630,212.80</b>	<b>684,005,724.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>337,625,830.44</b>	<b>323,092,807.39</b>
210101	Үндсэн цалин	164,453,172.64	157,179,706.17
210102	Нэмэгдэл	129,703,912.80	129,462,744.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,470,000.00	17,827,000.00
210104	Урамшуулал	33,998,745.00	18,623,357.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>41,919,763.25</b>	<b>41,924,532.01</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,656,922.76	29,010,935.41
210202	Тэтгэмжийн даатгал	2,697,122.02	2,584,295.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,371,402.75	3,230,369.18
210204	Ажилгүйдлийн даатгал	654,028.66	645,357.44
210205	Эрүүл мэндийн даатгал	6,540,287.06	6,453,574.82
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>82,454,813.80</b>	<b>83,562,433.96</b>
210301	Гэрэл, цахилгаан	62,517,063.80	63,207,683.96
210302	Түлш, халаалт	19,937,750.00	20,163,500.00
210303	Цэвэр, бохир ус	-	191,250.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,748,863.06</b>	<b>18,129,423.11</b>
210401	Бичиг хэрэг	1,067,490.00	2,342,380.00
210402	Тээвэр, шатахуун	6,680,785.00	7,470,015.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	52,300.00	64,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,045,100.00	1,656,450.00
210408	Бараа материал акталсны зардал	10,903,188.06	6,596,278.11
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,392,193.00</b>	<b>11,577,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	397,890.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,149,500.00	6,752,100.00
210604	Урсгал засвар	6,844,803.00	4,825,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,280,950.00</b>	<b>5,607,530.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,444,000.00	744,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	236,575.00	211,825.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,060,375.00	4,651,705.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>105,207,799.25</b>	<b>200,111,098.03</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,111,060.00	488,260.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	103,096,739.25	199,622,838.03
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>145,635,935.83</b>	<b>129,068,491.40</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>145,635,935.83</b>	<b>129,068,491.40</b>

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	145,635,935.83	129,068,491.40
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>405,108,864.95</u></b>	<b><u>(118,834,907.03)</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,234,635.55</b>	<b>33,110.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,234,635.55	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	33,110.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>398,874,229.40</u></b>	<b><u>(118,868,017.03)</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,033,555,220.61	456,641.84	(240,762,829.39)	1,793,249,033.06
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	280,058,000.00	-	-	280,058,000.00
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	398,874,229.40	398,874,229.40
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,313,613,220.61	456,641.84	158,111,400.01	2,472,181,262.46
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,313,613,220.61	456,641.84	158,111,400.01	2,472,181,262.46
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(118,868,017.03)	(118,868,017.03)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,313,613,220.61	456,641.84	39,243,382.98	2,353,313,245.43

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>668,476,923.58</b>	<b>607,875,054.90</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>38,269,423.58</b>	<b>17,625,254.90</b>
120	Нийтлэг татварын бус орлого	38,269,423.58	17,625,254.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,269,423.58	17,625,254.90
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	38,269,423.58	17,625,254.90
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>630,207,500.00</b>	<b>590,249,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>630,207,500.00</b>	<b>590,249,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	630,207,500.00	590,249,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>668,476,923.58</u></b>	<b><u>592,830,054.90</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>668,476,923.58</b>	<b>592,830,054.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>522,840,987.75</b>	<b>468,556,763.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>337,698,958.46</b>	<b>323,149,512.31</b>
210101	Үндсэн цалин	194,371,735.73	186,692,124.39
210102	Нэмэгдэл	100,844,477.73	99,014,954.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,484,000.00	14,824,500.00
210104	Урамшуулал	33,998,745.00	22,617,933.56
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>41,906,967.38</b>	<b>41,837,342.23</b>
210201	Тэтгэврийн даатгал	30,215,814.93	28,749,270.09
210202	Тэтгэмжийн даатгал	2,738,805.32	3,182,386.04

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,428,155.66	2,806,753.69
210204	Ажилгүйдлийн даатгал	593,108.19	645,357.45
210205	Эрүүл мэндийн даатгал	5,931,083.28	6,453,574.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>81,317,363.80</b>	<b>83,045,333.96</b>
210301	Гэрэл, цахилгаан	62,517,063.80	63,207,683.96
210302	Түлш, халаалт	18,665,500.00	19,480,500.00
210303	Цэвэр, бохир ус	134,800.00	357,150.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,795,270.00</b>	<b>9,028,750.00</b>
210401	Бичиг хэрэг	1,146,070.00	1,206,450.00
210402	Тээвэр, шатахуун	7,850,800.00	6,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	52,300.00	64,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	112,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,746,100.00	1,346,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>46,014,273.11</b>	<b>10,540,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,497,890.00	804,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,731,100.00	2,810,100.00
210604	Урсгал засвар	39,785,283.11	6,925,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,108,155.00</b>	<b>955,825.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,444,000.00	744,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	172,225.00	211,825.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	887,580.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>145,635,935.83</b>	<b>124,273,291.40</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,200,200.00</b>	<b>-</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,200,200.00	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>140,435,735.83</b>	<b>124,273,291.40</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	140,435,735.83	124,273,291.40
213504	Хөрөнгийн	-	-
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	-	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>≡</b>	<b><u>15,045,000.00</u></b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		<b>15,045,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>15,045,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>15,045,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		15,045,000.00
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>-</b>
226001	Гадаад эх үүсвэрээр	-	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>≡</b>	<b><u>(15,045,000.00)</u></b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>593,749,800.00</b>	<b>483,601,763.50</b>	<b>110,148,036.50</b>	<b>81.45</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>593,749,800.00</b>	<b>483,601,763.50</b>	<b>110,148,036.50</b>	<b>81.45</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>593,749,800.00</b>	<b>483,601,763.50</b>	<b>110,148,036.50</b>	<b>81.45</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>344,964,100.00</b>	<b>323,149,512.31</b>	<b>21,814,587.69</b>	<b>93.68</b>
210101	Үндсэн цалин	194,371,700.00	186,692,124.39	<b>7,679,575.61</b>	96.05
210102	Нэмэгдэл	107,108,400.00	99,014,954.36	<b>8,093,445.64</b>	92.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,484,000.00	14,824,500.00	<b>3,659,500.00</b>	80.20
210104	Урамшуулал	25,000,000.00	22,617,933.56	<b>2,382,066.44</b>	<b>90.47</b>
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,800,300.00</b>	<b>41,837,342.23</b>	<b>2,962,957.77</b>	<b>93.39</b>
210201	Тэтгэврийн даатгал	29,302,100.00	28,749,270.09	<b>552,829.91</b>	98.11
210202	Тэтгэмжийн даатгал	2,479,700.00	3,182,386.04	<b>(702,686.04)</b>	128.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,199,300.00	2,806,753.69	<b>3,392,546.31</b>	45.28
210204	Ажилгүйдлийн даатгал	619,900.00	645,357.45	<b>(25,457.45)</b>	104.11
210205	Эрүүл мэндийн даатгал	6,199,300.00	6,453,574.96	<b>(254,274.96)</b>	104.10
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>146,815,000.00</b>	<b>83,045,333.96</b>	<b>63,769,666.04</b>	<b>56.56</b>
210301	Гэрэл, цахилгаан	117,533,000.00	63,207,683.96	<b>54,325,316.04</b>	<b>53.78</b>
210302	Түлш, халаалт	27,782,000.00	19,480,500.00	<b>8,301,500.00</b>	<b>70.12</b>
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	357,150.00	<b>1,142,850.00</b>	<b>23.81</b>
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,491,900.00</b>	<b>9,028,750.00</b>	<b>5,463,150.00</b>	<b>62.30</b>
210401	Бичиг хэрэг	2,497,000.00	1,206,450.00	<b>1,290,550.00</b>	48.32
210402	Тээвэр, шатахуун	8,500,000.00	6,300,000.00	<b>2,200,000.00</b>	74.12
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	831,600.00	64,300.00	<b>767,300.00</b>	7.73
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	447,400.00	112,000.00	<b>335,400.00</b>	25.03
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,215,900.00	1,346,000.00	<b>869,900.00</b>	60.74
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>37,708,500.00</b>	<b>25,585,000.00</b>	<b>12,123,500.00</b>	<b>67.85</b>

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	5,813,600.00	5,809,100.00	4,500.00	99.92
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,894,900.00	4,310,100.00	7,584,800.00	36.23
210604	Урсгал засвар	20,000,000.00	15,465,800.00	4,534,200.00	77.33
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,000,000.00</b>	-	<b>1,000,000.00</b>	-
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	-	1,000,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,970,000.00</b>	<b>955,825.00</b>	<b>3,014,175.00</b>	<b>24.08</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,400,000.00	744,000.00	656,000.00	53.14
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	-	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	-	200,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	230,000.00	211,825.00	18,175.00	92.10
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	-	100,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.00	-	1,500,000.00	-
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>593,749,800.00</b>	<b>483,601,763.50</b>	<b>110,148,036.50</b>	<b>81.45</b>
<b>120</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,500,000.00</b>	-	<b>3,500,000.00</b>	-
120005	Төрийн өмч түрээслүүлсний орлого	3,500,000.00	-	3,500,000.00	-
120004	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	17,625,254.90	(17,625,254.90)	-
1200042	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	17,625,254.90	(17,625,254.90)	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>590,249,800.00</b>	<b>590,249,800.00</b>	-	<b>100.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>590,249,800.00</b>	<b>590,249,800.00</b>	-	<b>100.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	590,249,800.00	590,249,800.00	-	100.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж

заасны дагуу Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовын туслах Э.Алтангэрэл, аудиторовын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01-16/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газар нь гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих, гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх үйл ажиллагаа явуулдаг, Сангийн яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг нь төрийн үйлчилгээний байгууллага, Улсын эдийн засаг, хүн ардын аюулгүй байдлыг хамгаалах, улсын төсөв бүрдүүлэх зорилготой.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 15,025.3 мянган уеер тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 11,268.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газар нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

#### Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	30.9	0	(30.9)
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	24,165.4	20,231.6	(3,933.8)
Үндсэн хөрөнгө	2,447,984.9	2,333,081.6	(114,903.3)
Нийт хөрөнгө	2,472,181.3	2,353,313.2	(118,868.1)
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,313,613.2	2,313,613.2	0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,472,181.3	2,353,313.2	(118,868.1)

Бараа материалын дансны үлдэгдэл 20,231.6 мянган төгрөг болж, 3,933.8 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагаандаа зарцуулсан 48,583.8 мянган төгрөгийн, акталсан 6,596.3 мянган төгрөгийн бараа материал нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,333,081.6 мянган төгрөг болж, 114,903.3 мянган төгрөгөөр буурсан нь акталж данснаас хассан хөрөнгийн 35,000.0 мянган төгрөг, анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн СҮЭ-6847 улсын дугаартай Ниссан патрол маркийн суудлын автомашиныг “Булган-А33А” Төрийн өмчит хувьцаат компанийн балансад шилжүүлсэн 71,000.0 мянган төгрөгөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс урсгал төсвийн худалдан авалтаар авсан 15,045.0 мянган төгрөгийн багаж, техник хэрэгсэл болон баримт ариутгагч, Гаалийн ерөнхий газраас

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Зүүн үзэмчин хошууны Зүүн хатавч боомтын захиргаанаас үнэ төлбөргүй барьж өгсөн 68,894.6 мянган төгрөгийн хөрөнгө, уурын зуух, уурын зуухны барилга, байгууламжаар тус тус нэмэгдсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 462,135.7 мянган төгрөгөөр буюу 40 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оны мөн үеэс 406,378.0 мянган төгрөгөөр буурсанаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 61,808.1 мянган төгрөгөөр буюу 8 хувиар буурсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 709,262.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 709,262.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 115,512.6 мянган төгрөгөөр бууруулж 593,749.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 593,749.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 590,249.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр, 3,500.0 мянган төгрөгийг төрийн өмч түрээслүүлсний төлбөрөөс бүрдүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 593,749.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 483,601.8 мянган төгрөгийг зарцуулж, 110,148.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Гаалийн ерөнхий газар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Зүүн үзэмчин хошууны Зүүн хатавч боомтын захиргаанаас 2020 онд үнэ төлбөргүй барьж өгсөн 68,894.6 мянган төгрөгийн уурын зуух, уурын зуухны барилгыг санхүүгийн тайланд толилуулсан байна

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### **Бусад асуудлын хэсэг:**

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

Нийт 4 аж ахуй нэгж байгууллага болон 1 хувь хүнтэй холбоотой 1,127.6 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газар нь 2021 онд нийт 749,093.6 мянган төгрөгийн 39 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 648,670.1 мянган төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байна.

Шилэн данстай холбоотой 648,670.1 мянган төгрөгийн зөрчил нь зөвхөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнд хамаарах 22 гүйлгээ болно.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 2,731.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 976.9 мянган төлбөрийн зөрчилд 1 акт тогтоож бүрэн биелүүлсэн, 1 зөрчилд өгсөн албан шаардлагын хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн, 1,754.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг биелүүлсэн байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	976.9	1	976.9	-	-	100.0
Албан шаардлага	1	-	1	-	-	-	100.0
Зөвлөмж	4	1,754.1	4	1,754.1	-	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>2,731.0</b>	<b>6</b>	<b>2,731.0</b>	-	-	<b>100.0</b>

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,038.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 776.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 134.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,127.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

1.1. Бараа материалын данснаас үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлсэн 776.6 мянган төгрөгийг Санхүүгийн үр дүнгийн тайланд Төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгийн орлогоор бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 хавсралтын 6.8-д “Үйл ажиллагааны мөнгөн орлого"-д төсвөөс авсан шилжүүлгийн орлого, төсөвт байгууллагын төлбөртэй ажил үйлчилгээний орлого, тусламжийн орлого зэрэг орох бөгөөд ,, , “үнэн зөв байдал”, “тодруулга ба толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын данснаас үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлсэн 776.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Санхүүгийн үр дүнгийн тайланд Төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгийн орлогоор бүртгэснийг уг дүнгээр санхүүгийн үр дүнгийн тайланг бууруулан дотоодын шилжилт хөдөлгөөнөөр бүртгэн залруулсан.

### 4.2 Төлбөрийн акт

Хөдөлмөрийн чадвар алдалтын акттай 1 хүний 4-12 сарын цалингаас ХХОАТ-ын хөнгөлөлт тооцоогүйгээс 134.0 мянган төгрөгийг цалингаас илүү суутгасан. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 23.1 "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна”,

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

### 4.3 Албан шаардлага

Нийт 4 аж ахуй нэгж байгууллага, 1 хувь хүнтэй холбоотой 1,127.6 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалт, “ үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 21 ширхэг 190,529.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна”, 6.2.1-д “Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон”, “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

#### 2. Шилэн данстай холбоотой асуудал

##### 2.1. Илрүүлэлт:

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудаст нийт 749,093.6 мянган төгрөгийн 39 мэдээллийг ил тод байршуулахаас 648,670.1 мянган төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 2.2. Өгсөн зөвлөмж:

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

Д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Данс хооронд шилжүүлсэн хөрөнгийг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор тайлагнасан	1	776.6	1	776.6						
2	Цалинг буруу тооцоолон олгосон	1	134.0			1	134.0				
3	Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй	1	1,127.6					1	1,127.6		
4	Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
<b>Дүн</b>		<b>4</b>	<b>2038.2</b>	<b>1</b>	<b>776.6</b>	<b>1</b>	<b>134.0</b>	<b>1</b>	<b>1,127.6</b>	<b>1</b>	<b>-</b>
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	648,670.1							1	648,670.1
<b>Дүн</b>		<b>-</b>	<b>648,670.1</b>							<b>-</b>	<b>648,670.1</b>
<b>Нийт дүн</b>		<b>5</b>	<b>650,708.3</b>	<b>1</b>	<b>776.6</b>	<b>1</b>	<b>134.0</b>	<b>1</b>	<b>1,127.6</b>	<b>1</b>	<b>648,670.1</b>